



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2021 оны 07 сарын 19 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

**Зохион байгуулалтын арга хэмжээг  
хэрэгжүүлэх тухай**

Төрийн албаны зөвлөлийн Эрүүл мэндийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн ээлжит 3 дахь удаагийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын дагуу Эрүүл мэндийн яам, ЗГХА-Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх албан хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Тангараг өргөх ёслолын үйл ажиллагааг 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдөр ёслол төгөлдөр зохион байгуулахыг Төрийн албаны зөвлөлийн Эрүүл мэндийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (С.Ариунтуяа)-д даалгасугай.

3. Монгол Улсын Их хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын шаардлага хангасан Эрүүл мэндийн яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Янжмаа, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлстийн дарга Г.Ганхуяг нарт Эрхэлсэн түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг ахиулан олгуулах саналыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн Эрүүл мэндийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (С.Ариунтуяа)-д үүрэг болгосугай.

4. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны тусгай шалгалтын болзол, журам”-ын дагуу ЗГХА-Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоог нөхөх хүсэлтийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн Эрүүл мэндийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (С.Ариунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭМБИЛЭГ

Төрийн албаны зөвлөлийн Эрүүл мэндийн  
яамны дэргэдэх салбар зөвлөлийн  
2021 оны 07 дугаар сарын 19 -ны  
өдрийн 04 дүгээр тогтоолын хавсралт

УХА0115  
33

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙН ТАНГАРАГ ӨРГӨХ  
АЛБАН ХААГЧДЫН НЭРС

Эрүүл мэндийн яам:

1. Г.Бат-Эрдэнэ- Тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн;
2. Н.Болормаа- Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн;
3. Т.Жавзандулам- Уламжлалт анагаах ухааны засал, эмийн бодлого, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн.

ЗГХА-Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар:

1. Б.Чинзориг- Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн мэргэжилтэн;
2. Ж.Сувд- Сонгон шалгаруулалт хариуцсан мэргэжилтэн;
3. Д.Пүрэвжал- Нэхэмжлэлийн хяналтын мэргэжилтэн;
4. Ч.Оюун-Эрдэнэ- Хяналтын зохицуулалт, чанарын үнэлгээний мэргэжилтэн;
5. Б.Доржханд- Санхүүжилтийн мэргэжилтэн.



БАТЛАВ.  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Ц.ЭРДЭМБИЛЭГ

### ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙН ТАНГАРАГ ӨРГҮҮЛЭХ ЁСЛОЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

#### Оролцогчид

- Төрийн албаны зөвлөлийн Эрүүл мэндийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн дарга, гишүүд
- ЭМЯ-ны газар, хэлтсийн дарга нарын төлөөлөл
- ЗГХА-ЭМДЕГ-ын дарга, газар, хэлтсийн дарга нарын төлөөлөл
- ЭМЯ болон ЗГХА-ЭМДЕГ-ын Тангараг өргөх албан хаагчид

**Хугацаа:** 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 15:00 цагт

**Хаана:** ЭМЯ-ны хурлын Б зааланд

Хугацаа	Үйл ажиллагаа	Хариуцах хүн	Албан тушаал
15:00-15.05	Тангараг өргөх ёслолын арга хэмжээний нээлт	Ц.Эрдэмбилэг	ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Төрийн албаны зөвлөлийн ЭМЯ-ны дэргэдэх Салбар зөвлөлийн дарга
15.05-15.15	Тангараг өргөх арга хэмжээнд оролцогчдыг танилцуулах	С.Ариунтуяа	Төрийн албаны зөвлөлийн ЭМЯ-ны дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
15.15-15.20	Тангараг өргөх албан хаагчдыг танилцуулах	С.Ариунтуяа	Төрийн албаны зөвлөлийн ЭМЯ-ны дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
15:20-15.30	Монгол Улсын төрийн захиргааны албан хаагчийн тангаргийг дуудна (оролцогчдын төлөөлөл)	ЗГХА-ЭМДЕГ-ын мэргэжилтэн Ч.Оюун-Эрдэнэ	Тангараг өргөх албан хаагчид
15:30-16.00	Монгол Улсын төрийн сүлдэнд мэхийн ёсолж, төрийн далбаанаас адис аван, Тангарагийн хуудсанд гарын үсэг зурж баталгаажуулах	С.Ариунтуяа	Төрийн албаны зөвлөлийн ЭМЯ-ны дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
16.00-16.15	Тангараг өргөх ёслолын арга хэмжээний хаалт	Ц.Эрдэмбилэг, ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Төрийн албаны зөвлөлийн ЭМЯ-ны дэргэдэх Салбар зөвлөлийн дарга ТАСЗ-ийн гишүүд	
16.15-16.30	Ёслолын арга хэмжээний зураг авахуулах		